

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Булган сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/138/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг  
2022 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд  
Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр  
Утас: 7034-2580 Цахим хаяг: [ankhbayard@audit.gov.mn](mailto:ankhbayard@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 7034-2716 Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: Г.Цэрэнлхам  
Утас: 7034-2495 Цахим хаяг: [Tserenlhamg@audit.gov.mn](mailto:Tserenlhamg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 100  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

**БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Ч.БАЛДАНДОРЖ ТАНАА**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


©/highereg/2022A4tool

006020404

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:\hichighereg\2022A4\bot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>53,854,568.99</b>	<b>44,823,653.99</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	28,634,568.99	37,269,888.99
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,931,500.00	3,271,500.00
35110	Тусгай зориулалттай материал	1,931,500.00	3,271,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	26,703,068.99	33,998,388.99
35410	Бичиг хэргийн материал	2,060,775.00	3,107,845.00
35420	Аж ахуйн материал	8,678,200.00	10,179,300.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,321,685.00	10,534,685.00
35440	Түлш, шатах тослох материал	278,789.99	374,939.99
35450	Барилгын засварын материал	2,049,859.00	2,387,859.00
35470	Бусад хангамжийн материал	7,313,760.00	7,413,760.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	25,220,000.00	7,553,765.00
36300	Тэжээлийн нөөц	25,220,000.00	7,553,765.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,166,667,747.75</b>	<b>3,225,982,413.61</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,166,667,747.75	3,225,982,413.61
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,688,572,515.77	2,748,264,681.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,709,916,147.70	2,634,705,664.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	(297,520,372.03)	(349,342,146.38)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	59,994,800.00	59,994,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(13,090,883.11)	(17,798,696.47)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	101,086,693.75	111,966,593.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(39,746,457.00)	(51,044,614.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	107,927,822.00	106,391,402.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,793,287.95)	(35,989,216.21)
39209	Зам, гүүрийн байгууламж	104,207,690.80	104,207,690.80
39210	Хуримтлагдсан элэгдэл	(39,054,625.62)	(43,766,931.12)
39214	Бусад үндсэн хөрөнгө	44,983,536.86	258,023,530.86
39215	Хуримтлагдсан элэгдэл	(24,338,549.63)	(29,083,395.83)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	478,095,231.98	477,717,731.96
39301	Програм хангамж	3,900,000.00	4,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(270,000.02)	(1,397,500.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	474,465,232.00	474,465,232.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,220,522,316.74</b>	<b>3,270,806,067.60</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>4,470,820.34</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	4,470,820.34
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	4,470,820.34
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	4,470,820.34
41361	Байгууллагад төлөх өглөг	-	4,470,820.34
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,220,522,316.74</b>	<b>3,266,335,247.26</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,220,522,316.74	3,266,335,247.26

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	603,075,965.08	603,075,965.08
51101	Өмч: - төрийн	603,075,965.08	603,075,965.08
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,342,537,062.98</b>	<b>2,401,645,128.03</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	2,342,537,062.98	2,355,832,197.51
51220	Тайлант үеийн үр дүн	-	45,812,930.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	274,909,288.68	261,614,154.15
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,220,522,316.74</b>	<b>3,270,806,067.60</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,132,347,793.00</b>	<b>1,342,186,939.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>294,401,150.00</b>	<b>239,585,655.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	294,401,150.00	239,585,655.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	294,401,150.00	239,585,655.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,867,612.00	25,816,226.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,319,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	184,994,538.00	213,769,429.00
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	25,220,000.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>837,946,643.00</b>	<b>1,102,601,284.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	134,005,643.00	228,774,384.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205,945,984.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	133,565,643.00	477,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	440,000.00	22,351,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	703,941,000.00	873,826,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	703,941,000.00	873,826,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,049,310,001.41</b>	<b>1,244,521,215.85</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,049,310,001.41</b>	<b>1,244,521,215.85</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,023,735,060.05	1,147,183,192.89
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	437,652,350.64	457,224,348.30
210101	Үндсэн цалин	314,662,763.78	316,882,682.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,537,543.86	4,665,090.64
210105	Гэрээт ажлын хөлс	117,452,043.00	135,676,574.98
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	54,751,245.00	59,027,876.42
210201	Тэтгэврийн даатгал	37,394,500.00	44,701,972.59
210202	Тэтгэмжийн даатгал	4,399,400.00	3,594,318.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,519,400.00	2,864,865.85
210204	Ажилгүйдлийн даатгал	879,800.00	708,355.90

**Булган аймгийн Булган сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210205	Эрүүл мэндийн даатгал	8,558,145.00	7,158,363.32
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>143,390,488.00</b>	<b>152,950,683.66</b>
210301	Гэрэл, цахилгаан	14,577,416.00	17,697,054.66
210302	Түлш, халаалт	120,160,620.00	125,193,337.00
210303	Цэвэр, бохир ус	8,652,452.00	10,060,292.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,718,253.00</b>	<b>30,176,263.00</b>
210401	Бичиг хэрэг	3,762,359.00	5,963,077.00
210402	Тээвэр, шатахуун	8,821,560.00	17,945,246.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,134,334.00	5,099,940.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,168,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>-</b>	<b>218,500.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	218,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,284,566.00</b>	<b>26,095,870.00</b>
210602	Тавилга	300,000.00	50,000.00
210604	Урсгал засвар	3,984,566.00	26,045,870.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>700,000.00</b>	<b>3,000,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	700,000.00	3,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>92,911,102.00</b>	<b>87,171,852.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,328,017.00	84,098,429.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	238,600.00	238,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	224,200.00	214,148.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,100,000.00
210807	Газрын төлбөр	708,285.00	443,675.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>272,327,055.41</b>	<b>331,317,799.51</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	77,471,079.71	216,465,829.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	940,000.00	80,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	193,915,975.70	114,771,970.51
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,574,941.36</b>	<b>97,338,022.96</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,270,650.00</b>	<b>48,529,700.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	29,949,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,270,650.00	18,579,800.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>304,291.36</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	304,291.36	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>48,808,322.96</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	47,160,137.96
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,648,185.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>83,037,791.59</b>	<b>97,665,723.15</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>95,101,189.67</b>	<b>51,852,792.63</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	363,606.67	51,852,792.63
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	94,737,583.00	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(95,101,189.67)</b>	<b>(51,852,792.63)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(12,063,398.08)</b>	<b>45,812,930.52</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	603,075,965.08	274,909,288.68	2,354,600,461.06	3,232,585,714.82
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>603,075,965.08</b>	<b>274,909,288.68</b>	<b>2,354,600,461.06</b>	3,232,585,714.82
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(12,063,398.08)	(12,063,398.08)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>603,075,965.08</b>	<b>274,909,288.68</b>	<b>2,342,537,062.98</b>	3,220,522,316.74
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>603,075,965.05</b>	<b>274,909,288.68</b>	<b>2,342,537,062.98</b>	3,220,522,316.71
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	13,295,134.53	13,295,134.53
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>603,075,965.08</b>	<b>274,909,288.68</b>	<b>2,355,832,197.51</b>	3,233,817,451.27
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(13,295,134.53)	-	(13,295,134.53)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	45,812,930.52	45,812,930.52
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>603,075,965.08</b>	<b>261,614,154.15</b>	<b>2,401,645,128.03</b>	3,266,335,247.26

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>862,814,255.00</b>	<b>1,128,529,510.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>24,867,612.00</b>	<b>25,928,226.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	24,867,612.00	25,928,226.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	24,867,612.00	25,928,226.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,867,612.00	25,928,226.00

<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>837,946,643.00</b>	<b>1,102,601,284.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	134,005,643.00	228,774,384.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	125,701,837.00	205,945,984.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,434,766.00	477,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	869,040.00	22,351,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	703,941,000.00	873,826,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	703,941,000.00	873,826,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>851,214,355.00</b>	<b>1,099,959,510.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>851,214,355.00</b>	<b>1,099,959,510.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>825,639,413.64</b>	<b>1,003,031,487.04</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	437,652,350.64	452,259,308.38
210101	Үндсэн цалин	314,662,763.78	311,917,642.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,537,543.86	4,665,090.64
210105	Гэрээт ажлын хөлс	117,452,043.00	135,676,574.98
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	54,751,245.00	59,027,875.00
210201	Тэтгэврийн даатгал	37,394,500.00	44,701,972.59
210202	Тэтгэмжийн даатгал	4,399,400.00	3,594,318.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,519,400.00	2,864,864.43
210204	Ажилгүйдлийн даатгал	879,800.00	708,355.90
210205	Эрүүл мэндийн даатгал	8,558,145.00	7,158,363.32
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	143,390,488.00	152,147,423.66
210301	Гэрэл, цахилгаан	14,577,416.00	17,697,054.66
210302	Түлш, халаалт	120,160,620.00	124,390,077.00
210303	Цэвэр, бохир ус	8,652,452.00	10,060,292.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,118,073.00	21,559,357.00
210401	Бичиг хэрэг	3,700,739.00	6,494,467.00
210402	Тээвэр, шатахуун	8,283,000.00	8,379,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,134,334.00	5,099,940.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,585,950.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	6,080,038.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,080,038.00	600,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,198,800.00	30,499,800.00
210602	Тавилга	50,000.00	-
210604	Урсгал засвар	7,148,800.00	30,499,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	700,000.00	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	700,000.00	3,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	88,171,912.00	93,049,852.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	86,588,827.00	89,976,429.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	238,600.00	238,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	224,200.00	214,148.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,100,000.00
210807	Газрын төлбөр	708,285.00	443,675.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>70,576,507.00</b>	<b>190,887,871.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,509,507.00	189,969,371.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,067,000.00	918,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,574,941.36</b>	<b>96,928,022.96</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,270,650.00</b>	<b>48,119,700.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	29,949,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,270,650.00	18,169,800.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>304,291.36</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	304,291.36	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>48,808,322.96</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	48,808,322.96
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>11,599,900.00</b>	<b>28,570,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>11,599,900.00</b>	<b>28,570,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,599,900.00</b>	<b>28,570,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>11,599,900.00</b>	<b>28,570,000.00</b>
223001	Бусад хөрөнгө	11,599,900.00	12,170,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		16,400,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(11,599,900.00)</b>	<b>(28,570,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт -, Хэмнэлт +
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	915,826,900.00	852,482,988.04	(63,343,911.96)
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	839,426,900.00	840,312,988.04	886,088.04
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	791,307,000.00	792,193,288.04	886,288.04

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	453,398,100.00	452,259,298.38	(1,138,801.62)
210101	Үндсэн цалин	305,675,900.00	311,917,632.86	6,241,732.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,040,000.00	4,665,090.64	(374,909.36)
210105	Гэрээт ажлын хөлс	142,682,200.00	135,676,574.88	(7,005,625.12)
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	60,457,300.00	59,027,885.00	(1,429,415.00)
210201	Тэтгэврийн даатгал	42,283,000.00	44,701,972.59	2,418,972.59
210202	Тэтгэмжийн даатгал	4,534,000.00	3,594,318.76	(939,681.24)
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,627,200.00	2,864,874.43	(762,325.57)
210204	Ажилгүйдлийн даатгал	906,800.00	708,355.90	(198,444.10)
210205	Эрүүл мэндийн даатгал	9,106,300.00	7,158,363.32	(1,947,936.68)
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	152,692,000.00	154,367,423.66	1,675,423.66
210301	Гэрэл, цахилгаан	18,050,000.00	17,697,054.66	(352,945.34)
210302	Түлш, халаалт	124,642,000.00	126,610,077.00	1,968,077.00
210303	Цэвэр, бохир ус	10,000,000.00	10,060,292.00	60,292.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,384,800.00	23,723,357.00	2,338,557.00
210401	Бичиг хэрэг	6,405,800.00	6,286,847.00	(118,953.00)
210402	Тээвэр, шатахуун	8,379,000.00	8,383,620.00	4,620.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,100,000.00	5,099,940.00	(60.00)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	3,952,950.00	2,452,950.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	600,000.00	600,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	33,500,000.00	20,279,800.00	(13,220,200.00)
210602	Тавилга	11,000,000.00	-	(11,000,000.00)
210604	Урсгал засвар	22,500,000.00	20,279,800.00	(2,220,200.00)
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,000,000.00	3,000,000.00	-
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00	3,000,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,274,800.00	19,473,423.00	15,198,623.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	16,400,000.00	15,900,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-	(324,000.00)
210803	Даатгалын үйлчилгээ	238,600.00	238,600.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	224,200.00	214,148.00	(10,052.00)
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	77,000.00	(11,000.00)
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00	2,100,000.00	-
210807	Газрын төлбөр	800,000.00	443,675.00	(356,325.00)

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	62,000,000.00	59,462,101.00	(2,537,899.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,000,000.00	58,543,601.00	(2,456,399.00)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	918,500.00	(81,500.00)
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	48,119,900.00	48,119,700.00	(200.00)
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	48,119,900.00	48,119,700.00	(200.00)
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,949,900.00	29,949,900.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,170,000.00	18,169,800.00	(200.00)
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>76,400,000.00</b>	<b>12,170,000.00</b>	(64,230,000.00)
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	76,400,000.00	12,170,000.00	(64,230,000.00)
223001	Бусад хөрөнгө	76,400,000.00	12,170,000.00	(64,230,000.00)
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	915,826,900.00	899,643,126.00	(16,183,774.00)
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	850,184,100.00	842,846,900.00	(7,337,200.00)
132001	Орон нутгийн төсвөөс	850,184,100.00	842,846,900.00	(7,337,200.00)
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	65,642,800.00	56,796,226.00	(8,846,574.00)
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,100,000.00	25,816,226.00	716,226.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	40,542,800.00	30,980,000.00	(9,562,800.00)
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>49</b>	<b>49</b>	-
620001	Удирдах ажилтан	9	9	-
620002	Гүйцэтгэх ажилтан	18	18	-
620003	Үйлчлэх ажилтан	9	9	-
620004	Гэрээт ажилтан	13	13	-
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>49</b>	<b>49</b>	-
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	18	18	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	23	23	-
650010	Гэрээт ажилтан		-	-
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>228,774,384.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>228,774,384.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	228,774,384.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	175,000.00
210401	Бичиг хэрэг	175,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,000,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>89,976,429.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,976,429.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>128,974,770.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	128,974,770.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,648,185.00</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1,648,185.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>228,774,384.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>228,774,384.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	205,945,984.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	477,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,351,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн толилуулга, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/55 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу тайлант онд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж ажилласан байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалы

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 837,962.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,379.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,865.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	53,854.57	44,823.65	9,030.92
Үндсэн хөрөнгө	3,166,667.75	3,225,982.41	59,314.66
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,220,522.32</b>	<b>3,270,806.06</b>	<b>50,283.74</b>
Богино хугацаат өр төлбөр	-	4,470.82	<b>4,470.82</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,220,522.32	3,266,335.24	<b>45,812.92</b>
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,220,522.32</b>	<b>3,270,806.06</b>	<b>50,283.74</b>

Тайлант хугацаанд орон нутгийн төсвөөс 873,826.9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 228,774.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 25,928.2 мянган төгрөгийг бүрдүүлэн нийт 1,128,529.5 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 1,079,721.2 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулан, 48,808.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 44,823.7 мянган төгрөг болж, 9,030.9 мянган төгрөгөөр буурсан нь бичгийн цаас, ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор маск, ариутгалын бодис, нэг удаагийн хувцас, шатахуун, өвс, хивэг, тэжээлийн будаа зэргийг нөөцөлсөн, бараа материал акталснаас нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,748,264.7 мянган төгрөг болж, 59,314.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр тавилга, тоног төхөөрөмжийг бэлтгэж, Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй ОНӨХХК-иас хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн борлуулах цэг, усалгааны систем (чацаргана), чацарганы хашаа зэргийг шилжүүлэн авч, барилга, байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил акталснаас нөлөөлжээ.

Дансны өглөгийн үлдэгдэл 4,470.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 100 хувь өссөн байна. Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бичилт хийгдээгүй, тайлант онд хөрөнгийн дахин үнэлгээний нөөц дансыг 13,295.1 мянган төгрөгөөр бууруулсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 925,618.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 25,975.6 мянган төгрөгөөр бууруулж 899,643.1 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн тодотголоор төсвийн захирагчийн төсөвт өөрчлөлт ороогүй байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн 6 чиглэлийн арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 850,184.1 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 65,642.8 мянган төгрөгийн нийт 915,826.9 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 842,846.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 25,816.2 мянган төгрөгийн өөрийн орлогыг бүрдүүлэн, урьд оны эхний үлдэгдлээс 30,980.0 мянган төгрөгийг авч, урсгал үйл ажиллагаанд 852,483.0 мянган төгрөгийг зарцуулж, 47,160.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 852,482.9 мянган төгрөг буюу 6.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 1,138.8 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,429.4 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 13,220.2 мянган төгрөгөөр буюу 39.4 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 2,537.9 мянган төгрөг буюу 4.1 хувиар тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилагдсан хөрөнгө 477.4 мянган төгрөг, ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 205,945.9 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 22,351.0 мянган төгрөг нийт 228,774.4 мянган төгрөгийн орлого хүлээн авч, бичиг хэргийн зардалд 175.0 мянган төгрөг, урсгал засварт 8,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 128,974.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаар 1,648.2 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Үндсэн хөрөнгийн 39201, 39205, 39207 дансанд 16 нэр төрлийн 10,681.7 мянган төгрөгийн хөрөнгө эзэмшилдээ байгаа элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох шаардлагатай байна. Үлдэх өртөг тэг үлдэгдэлтэй ашиглалтын хугацаа бүрэн дууссан хөрөнгөнд нэмж элэгдлийн зардал байгуулагдахгүйгээс тухай тайлант хугацааны элэгдлийн зардал үнэн зөв илэрхийлэгдэхгүй дутуу тайлагнагдаж байна.

Мөн нэмэлт санхүүжилтийн данс болон үндсэн үйл ажиллагааны зориулалтаас бусад арга хэмжээний зардлыг зарцуулахдаа зардлын эдийн засгийн ангиллаар зарцуулахаар зарцуулалтын эрх олгоогүйгээс шалтгаалж, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дүнтэй зөрүүтэй илэрхийлэгдэж байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 128 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба сар бүр 96 мэдээлэл, улирал бүр 4 мэдээлэл оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

✚ Шилэн дансны нэгдсэн [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлээгүй нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй,

✚ Мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй,

✚ Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналт хангалтгүй нь дотоод хяналтын талаарх Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Өөрийн эзэмшилдээ байгаа боловч хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн ашиглалтын хугацаа дууссан ч ашиглагдаж байгаа хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн шинэчлэн тогтоох, нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулалтын эрх нээхдээ Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 78,485.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 58,633.5 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1,170.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн үр дүнгийн тайланд 58,633.5 мянган төгрөгийн алдааг тусгаж баталгаажуулав. Энэ нь УСНББОУС 27-д “санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, “Үнэн зөв толилуулга” нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг”, НББОУС 8-ын 10.Б.1-д “аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, санхүүгийн гүйцэтгэл ба мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлэх” заалтуудтай нийцэхгүй, “эрх ба үүрэг”, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### **4.2 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### **4.3 Албан шаардлага**

4.3.1 Тавилга, багаж техник худалдан авах зардлаас 1,170.0 мянган төгрөгөөр 1,4-р багийн гадна хаягны үсэг худалдан авсан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэхь заалтыг хэрэгжүүлээгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгаад Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин тавилга эд хогшил бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоож, “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Дотоод хяналттай холбоотой асуудал

###### 1.1. Илрүүлэлт:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу 2020-2021 хичээлийн жилд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж ажиллаагүй байна.

###### 1.2. Өгсөн зөвлөмж:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж, дотоод хяналт шалгалтын баг томилуулан ажиллуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Булган сумын ЗДТГ	3	78,485.2	1	58,633.5	0	0	1	1,170.0	1	0

/сая төгрөгөөр/